



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 9 сарын 7 өдөр

Дугаар 342

Улаанбаатар хот

Г
Барилга угсралтын ажлын
гэрээг цуцалж, шууд гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь хэсэг, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Суурь" ХХК-ний 08/288 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч Худалдаа. Үйлдвэрлэл үйлчилгээний "Суурь" ХХК-тай байгуулсан гэрээг цуцалсугай.

2. 2011 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн барилгад суурилуулах техник, тоног төхөөрөмж 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсад ирж, шууд угсралдах гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тул барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх гэрээг "Зүр констракшн" ХХК-тай шууд байгуулсугай.

3.Гэрээ шууд байгуулах болон "Суурь" ХХК-иас ажил хүлээн авах, "Зүр констракшн" ХХК-д хүлээлгэн өгөх ажлыг шуурхай зохион байгуулахыг Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга / Г.Ганчимэгт /-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

031224